

# УЛААНБААТАР:

"Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн  
ба хэрэгцээ шаардлага"  
Түргэвчилсэн судалгаа

2022 оны 7-р сар



© З.Эрдэнэ

# Агуулга


Гол дүгнэлтүүдийн хураангуй.....	1
Арга зүй.....	3
Мэдээллийн дүн шинжилгээ.....	5
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	7
1.2 Ирсэн иргэд.....	8
1.3. Явсан иргэд.....	8
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	9
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	11
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	12
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	16
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	20
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	21
1.10 Хүүхэд болон боловсрол.....	23

Хавтасны зураг: © Ү.Одбаяр

Энэхүү хэвлэл нь ОУШХБ-ын албан ёсны баталгаажуулалтгүйгээр гарсан болно.  
Дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэн нийтлэгчээс авна уу.

Нийтлэгч: Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ) -  
Монгол Улс  
НҮБ-ын байр, 307 тоот  
НҮБ-ын гудамж - 12  
Сүхбаатар дүүрэг  
14201 Улаанбаатар  
Монгол Улс  
Утас: +976 - 70 14 31 00  
Имэйл: IOMUlanbator@iom.int

© ОУШХБ 2022



Зарим эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү бүтээлийг Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivs 3.0 IGO лицензийн дагуу (CC BY-NC-ND 3.0 IGO) ашиглах боломжтой. \*

Нэмэлт үзүүлэлтүүдийн талаар зохиогчийн эрх болон ашиглалтын нөхцлийг харна уу.

Энэхүү нийтлэлийг боловсролын зорилгоос бусад тохиолдолд жишээлбэл, эрдэм шинжилгээний сурах бичигт оруулах, ашгийн төлөө худалдаалах, нийтлэх, тараахыг хориглоно.

Зөвшөөрөл: Арилжааны зориулалтаар ашиглах эсвэл нэмэлт эрх, лиценз авах хүсэлтийг publications@iom.int хаягаар илгээх боломжтой.

\*<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/3.0/igo/legalcode>

# Удиртгал ба судалгааны үр дүнгийн тойм

## Удиртгал

Энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг авч үзсэн болно. Мэдээллийг дүүрэг, хэсгийн нутаг дэвсгэрийн байдал, мэдээлэл нэгтгэгчийн нөөц бололцоо, мэдээллийн нээлттэй байдлаас хамааран хэсгийн ахлагч нар ярилцлага хийх замаар цуглуулсан болно.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-ын өмнөх судалгаануудаас харахад газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг төвөгтэй хүчин зүйлс Монгол Улсын уламжлалт амьдралын хэв маягийг өөрчилж байгааг тогтоожээ. Ган, зудын давтамж нэмэгдэж, ажлын байр цөөн, амьдрах орчин нөхцөл хангалтгүй, хөдөөгийн хүн амын мал аж ахуйгаас хараат байдал зэрэг нь суурин газар болон бусад орон нутаг уруу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсоор байна.

Тэдгээр шилжих хөдөлгөөний үндсэн шинж чанарыг ойлгоход Монгол Улсын өөр өөр байршилд амьдарч шилжин суурьшиж буй хүн амын тооллого, бүртгэлийн мэдээлэл шаардагдах бөгөөд мэдээллийн зөрүүтэй байдал саад болж байна.

## Судалгааны үр дүнгийн тойм

### Хүн амын суурь тоон үзүүлэлт

Үнэлгээ хийх үед (2022 оны 3-р сар) Улаанбаатар хотод 1,499,936 хүн амьдарч байснаас тооцоход нэг өрх дунджаар 3-4 гишүүнтэй байна. Нийт хүн амын 52 хувь нь эмэгтэй, 48 хувь нь эрэгтэй байв. Хүн амын 33 хувь нь насанд хүрээгүй хүүхдүүд (0-5 насныхан 11 хувь, 6-17 насныхан 22 хувь), 61 хувь нь 18-65 насны насанд хүрэгчид, 6 хувь нь өндөр настнууд (65-аас дээш насны) байна. Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай эхний гурван дүүрэгт нийслэлийн хүн амын гуравны хоёр шахам хувийг (62 хувь) бүрдүүлдэг Баянзүрх дүүрэг (356,807 иргэн), Сонгинохайрхан дүүрэг (335,554 иргэн), Баянгол дүүрэг (238,067 иргэн) орсон байна.

Харьцуулбал, бүртгэлийн мэдээлэлд 2021 оны байдлаар Улаанбаатар хотод нийт 1,539,252 иргэн оршин сууж байна гэснийг энэхүү судалгааны үр дүнтэй харьцуулахад +2.6 хувийн зөрүүтэй байгааг харуулж байна. Сүхбаатар дүүрэг (+13 хувь), Баянзүрх дүүрэг (+7 хувь), Налайх (-7 хувь) дүүргүүдэд хүн амын суурь тоон үзүүлэлт болон бүртгэлийн мэдээллийн тоо хооронд хамгийн их зөрүүтэй байна.

## Шилжин ирэгсэд ба явагсад

2021 онд Улаанбаатар хотын 9 дүүргийн хэмжээнд 119,914 хүн шилжин ирж, 86,428 хүн явсан байна. Иймээс нийтдээ нийслэлд шилжин ирэгсдийн тоо явсан иргэдийн тооноос илүү тоологдсон байна. Дүүрэг хоорондын хөдөлгөөний тоон мэдээлэл шилжин ирэгсэд, явагсдын гол мэдээллийг бүрдүүлдэг гэдгийг анхаарах нь зүйтэй. Нийслэлийн дүүргүүдийн хэмжээнд ердөө 25,695 иргэн бүртгүүлсэн гэх судалгааны дүн нь албан ёсны статистик мэдээнээс эрс ялгаатай байна. Мөн энэ зөрүүтэй мэдээлэл нь шилжин явсан иргэдийн мэдээллийг хороо, хэсэгт хасалт хийхээ больсон, албан ёсоор шилжин ирсэн газарт нь бүртгэл хийх болсонтой холбоотой байх магадлалтай юм.

Хамгийн их хүн шилжин ирснийг мэдээлсэн гурван дүүрэгт Баянзүрх (нийт шилжин ирэгсдийн 24 хувь), Сонгинохайрхан (21 хувь), Хан-Уул (17 хувь) орсон байна. Дүүргүүдийн шилжин ирэгсдийн дийлэнх нь гэр бүлийн шалтгаанаар нэг дүүргээс нөгөө дүүрэг рүү, эсвэл хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин ирсэн байсан бол Баянгол дүүрэгт шилжин ирсэн иргэдийн дийлэнх нь боловсролын шалтгаанаар ирсэн байв.

Хамгийн их хүн шилжин явсан гурван дүүрэгт Сонгинохайрхан дүүрэг (25 хувь), Сүхбаатар дүүрэг (18 хувь), Чингэлтэй дүүрэг (16 хувь) орсон байна. Ирсэн хүмүүсийн нэгэн адил ихэнх дүүргээс шилжин явсан шалтгаан нь гэр бүлийн шалтгаан байна. Харин Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргээс шинээр баригдсан орон сууцны хороололд амьдрахаар шилжин явсан тохиолдол зонхилж байна.

## Нийгэм, эдийн засгийн байдал; тулгамдаж буй асуудал; үйлчилгээний хүртээмж, дэд бүтэц; боловсрол

Улаанбаатар хотын бүх дүүрэгт иргэдийн төлбөрийн чадвар буурсан асуудал санхүүгийн бэрхшээлүүдийн үндсэн шалтгаан болж байна. Нийтдээ 270,079 хүн судалгаа хийх явцад хөдөлмөр эрхлээгүй гэж тоологдсон нь хөдөлмөрийн насны хүн амын 30 хувь байна. 639,498 хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас хөдөлмөр эрхлэлтийн зонхилох үндсэн салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа (29 хувь), дараа нь барилга (24 хувь) байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн эх үүсвэр нь хувийн хэвшил бөгөөд ажил, хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын гуравны хоёр гаруйг (68 хувь) эзэлж байна.

Энэхүү үнэлгээний явцад илэрсэн төлбөрийн чадварын өөр чухал бэрхшээлтэй асуудал бол өрхийн орлого өргөн хүрээнд буурсан буюу орлогын эх үүсвэрээ алдсан явдал их байв. Улаанбаатар хотын дүүргийн 18 хувьд мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд нийт хүн амын 50 буюу түүнээс дээш хувь нь орлого нь буурсныг мэдэгдсэн; Дүүргүүдийн 12 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд хүн амын 50 ба түүнээс дээш хувь нь бүх орлогоо алдсан гэж мэдээлсэн. Цаашилбал, нийслэлд хамгийн их бүртгэгдсэн тулгамдсан асуудал бол орлого хангалтгүй (47 хувь), ажилгүйдэл (хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь 23 хувь), өрийн дарамт (13 хувь) гэж тоологдсон байна.

Төлбөрийн чадвар муудсан гэх тулгамдсан асуудалтай хүнсний хүртээмжтэй байдал нь шууд хамааралтай бөгөөд бас маш чухал сорилт болох нь тогтоогдсон юм. Бүх дүүргийн хэсгийн 40 хувьд нь орлого буурснаас болж хоол хүнс нь хүрэлцэхгүй байхад санаа зовж буй айл өрхүүд байгаа талаар гол мэдээлэгч нар мэдээлсэн. Хэсгүүдийн 31 хувьд нь гол мэдээлэгч нар хоол хүнсний хэрэглээгээ эрс багасгахаас өөр аргагүйд хүрсэн айл өрхүүд байгаа талаар мэдэж байгаагаа илтгэжээ.

Энэхүү тайланд мөн төрийн үйлчилгээ, дэд бүтэц (ус, хоол, цахилгаан, орон сууц, хүнсний бус зүйлс, эрүүл мэнд, интерэт, ухаалаг утас)-ийн хүртээмж, түүнд тулгамдаж буй асуудлуудыг тусгасан болно. Хэсгүүдийн 9 хувьд нь гол мэдээлэгч нар хүн амын 50 ба түүнээс дээш хувь нь хоол хүнс авах боломжгүй байна гэж мэдээлжээ. Хэсгүүдийн дөнгөж 38 хувь нь тухайн хэсэгт хүнсний асуудал байхгүй гэж хариулсан бол 46 хувь нь хүнсний бүтээгдэхүүний үнэ хэт өндөр байгаа нь худалдан авах чадвар буурсан нь гол асуудал болдог гэж хариулсан байна.

Судалгааны үр дүнд сургууль, цэцэрлэгт хамрагдах болон боловсролын чанартай холбоотой асуудлууд нь залуучуудад тулгамдаж буй асуудалд багтсан байна. Улаанбаатар хотын хэмжээнд 0-5 насны хүүхдүүдийн 30 хувь нь цэцэрлэгт хамрагддаггүй бол 6-17 насны хүүхдүүдийн 3 хувь нь сургуульд сурдаггүй гэж мэдээлжээ. Боловсролын хүртээмжтэй холбоотой гол асуудал нь сургуулийн зай хэт хол (26 хувь) байдаг бол хүүхдүүдэд тулгамдаж буй нийтлэг асуудал нь хүүхдүүдэд зориулсан дугуйлан, спортын төв гэх мэт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх байгууламжууд дутмаг (40 хувь) байдаг талаар мэдээлжээ.



# Судалгааны аргачлал

## Судалгааны аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулсан юм. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо болон харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм. Хэсгийн ахлагч нар Кобо программ хангамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээв. Мэдээллийг зөв, чанартай нэгтгэхийн тулд Улаанбаатар хотын 9 дүүргийн 1765 хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.

Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн

зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

## Хязгаарлагдмал байдал

Энэхүү судалгаанд ашигласан аргачлал нь гол мэдээлэгч нараас өгсөн мэдээлэлд тулгуурласан бөгөөд бусад эх сурвалжтай гурвалсан өгөгдлийн санг бий болгох зорилготой юм.

Цуглуулсан өгөгдөл нь гол мэдээлэгч нарын тооцоолол, төсөөллийг илэрхийлдгээрээ бодит баримтаас ялгаатай. Тиймээс өгөгдлийн найдвартай байдал нь ажиглалтын нэгжийн хэмжээ (жишээ нь, хэсгийн хэмжээ, хүн ам), тодорхой хэсгийн ахлагчийн иргэдтэй хэр ойр холбоотойгоос шалтгаалсан мэдлэгийн хүрээ зэрэг олон хүчин зүйлээс хамаарч ялгаатай байх тул өгөгдлийн гадаад болон дотоод хүчин төгөлдөр байдал хязгаарлагдмал юм.

Нэмж дурдахад, тоон мэдээллийн үр дүнгийн гурвалжинд тусгасан үнэлгээ нь тухайн ажиглалт хийсэн байршилд зөвхөн нэг гол мэдээлэгчээс авсан мэдээллээр хязгаарлагдсан болно.

## Газар зүйн хамрах хүрээ ба гол мэдээлэгчийн талаар<sup>1</sup>

Дүүрэг	Хэсгийн тоо	Хүн амын тоо	Давамгайлсан орон байрны төрөл	Гол мэдээлэгч - эмэгтэйчүүдийн хувь
Баянзүрх	395	356,807	Орон сууц	89%
Сонгинохайрхан	355	335,554	Гэр	96%
Баянгол	254	238,067	Орон сууц	89%
Хан-Уул	201	216,980	Холимог	90%
Чингэлтэй	195	149,879	Гэр	95%
Сүхбаатар	179	126,321	Холимог	95%
Налайх	50	41,628	Гэр	100%
Багануур	34	30,124	Гэр	97%
Багахангай	6	4,576	Холимог	100%
<b>Нийт</b>	<b>1,669</b>	<b>1,499,936</b>		<b>92%</b>

## Нэр томъёоны тодорхойлолт

**Хүн амын суурь тоон үзүүлэлт:** Гарал үүсэл, бичиг баримтын байдал, бүртгэл, нас, нийгэм-хүн ам зүйн бусад шинж чанараас үл хамааран үнэлгээ хийх үед тухайн байршилд байгаа бүх оршин суугч.

**Өрх:** Нэг дээвэр дор амьдардаг, зардал болон хоол хүнсээ хуваалцдаг бүлэг хүмүүс.

**Ирсэн иргэд:** Улаанбаатар хот дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран хамгийн багадаа дөрвөн долоо хоног оршин суух зорилготой ямар нэг байршилд ирсэн хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийсэн эсэхээс үл хамаарна).

**Явсан иргэд:** Улаанбаатар хот дотор эсвэл хотын гадна ас явсан эсэхээс үл хамааран хамгийн багадаа дөрвөн долоо хоногийн турш буцах бодолгүй, нэг газраас явсан хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийсэн эсэхээс үл хамаарна).

**Хүнсний бус зүйлс (NFIs):** Хоол хүнснээс бусад зүйл буюу ихэвчлэн гудас, хөнжил, орны даавуу, усны сав, хоол хийх сав суулга, эрүүл ахуйн хэрэглээний зүйлс, халаагуур, аяны хөнжил, өвлийн хувцас зэрэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг хэлдэг.

**Мэдээлэгч:** Мэдээллийн эх сурвалж бөгөөд энэ судалгаанд хэсгийн ахлагч нарыг хэлнэ.

**Мэдээлэл нэгтгэгч:** Мэдээлэл цуглуулж буй хүн. Энэхүү үнэлгээнд гол мэдээлэгч нар мэдээлэл нэгтгэсэн тул эдгээр хоёр нэр томъёо давхцаж байна.

**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин:** Үндсэн мэдээлэгчийн ажигласнаар газар зүйн бүсэд долоо хоногийн ихэнх өдөр ажил, хөдөлмөр эрхэлж байгаа гэж мэдээлсэн хүмүүсийн тоо.

**Хөдөлмөр эрхлээгүй хүн амын үзүүлэлт:** Үндсэн мэдээлэгчийн ажигласнаар судалгааны үед газар зүйн бүсэд долоо хоногт ихэнх өдөр ажил хөдөлмөр эрхлээгүй гэж мэдээлсэн хүмүүсийн тоо.

<sup>1</sup> Орон байрны төрлүүдийн талаарх мэдээллийг Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан ба мэдээллийг хороодын түвшинд өгсөн бөгөөд энэхүү үнэлгээний зорилгоор дүүрэг тус бүрийн ихэнх хороодын орон байрны төрлийг харгалзан дүүргийн түвшинд нэгтгэв. Дүүргүүд нь тэнцүү тооны гэр хороолол, орон сууцны хороололоос бүрдсэн тохиолдолд дүүргийг холимог гэж тэмдэглэсэн. Дүүргүүд нь ижил тооны холимог, орон сууц, гэр хороололоос бүрдсэн тохиолдолд гэр хороо гэж тэмдэглэсэн.







Улаанбаатар:  
Мэдээллийн  
дүн  
шинжилгээ

# 1. Мэдээллийн дүн шинжилгээ

## 1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь %)




Үнэлгээ хийх үед (2022 оны 3-р сар) Улаанбаатар хотод 1,499,936 иргэн, 397,015 өрх бүртгэгдсэн байна. Үүнээс 48 хувь нь эрэгтэй, 52 хувь нь эмэгтэй байв. Хүн амын 33 хувь нь хүүхэд гэж бүртгэгдсэнээс 11 хувь нь 0-5 насны, 22 хувь нь 6-17 насныхан байна. Хүн амын 61 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 6 хувийг өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 23,570 хүн архаг өвчтэй эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1,6 хувь), 15,908 эмэгтэй (эмэгтэйчүүдийн 2,0 хувь) жирэмсэн гэж бүртгэгджээ.

Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн олон хүн амтай гурван дүүрэгт Баянзүрх (нийт хүн амын 24 хувь), Сонгинохайрхан (22 хувь), Баянгол (16%) багтжээ. Хамгийн цөөн хүн амтай гурван дүүрэг нь Багахангай (нийт хүн амын 1 хувь хүрэхгүй), Багануур (2 хувь), Налайх (3 хувь) байв.


Хүн ам зүйн тойм хүйсээр, дүүргээр (эзлэх хувь)



## 1.2 Ирсэн иргэд<sup>2</sup>

2021 онд Улаанбаатар хотод нийт 40,230 өрх буюу 119,914 иргэн оршин суухаар иржээ (албан ёсны шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлэгсэн болон хийлгээгүй аль аль нь багтсан). Ирсэн хүмүүсийн хамгийн өндөр хувийг Баянзүрх дүүрэг (24 хувь), Сонгинохайрхан дүүрэг (21 хувь), Хан-Уул (17 хувь) эзэлж байна. Сүхбаатар дүүрэг нь дүүргийн хэмжээнд дөрөвдүгээрт жагссан (2021 онд ирэгсдийн 14 хувийг шингээсэн) нь нийт хүн амын дөнгөж 8 хувийг эзэлж байгаа юм. Боловсрол эзэмших зорилгоор Баянгол дүүрэгт хамгийн их хүмүүс ирсэн бол бусад дүүрэгт ирсэн иргэдийн дийлэнх нь гэр бүлийн шалтгаантай байв.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн 5 дүүрэг (эзлэх хувь)




## 1.3 Явсан иргэд

2021 онд Улаанбаатар хотоос нийт 25,574 өрх буюу 86,428 иргэн явжээ. Явагсдын хамгийн өндөр хувь нь Сонгинохайрхан (25%), Сүхбаатар (18%), Чингэлтэй (16%) дүүрэгт бүртгэгдсэн байна. Ирсэн иргэдийн нэгэн адилаар ихэнх дүүргийн иргэдийн дийлэнх нь гэр бүлийн үндсэн шалтгаанаар явжээ. Гэхдээ Баянзүрх, Сонгинохайрхан (хамгийн их хүн шилжин явсан), Сүхбаатар (хоёрдугаарт ордог) дүүрэгт шинээр баригдсан орон сууцны хороололд амьдрах болсон нь явах гол шалтгаан болсон байна.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн 5 дүүрэг (эзлэх хувь)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд, дүүргээр




<sup>2</sup> Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль байршилд оршин явсанаас үл хамааран хотоос явсан иргэн, айл өрхийг хэлнэ.

### 1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Улаанбаатар хотын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа (29%), дараа нь барилга (24%), үйлдвэрлэл (9%) байна. Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт ажиллаж буй хүмүүсийн хамгийн их хувь Баянгол дүүрэгт (44%) байгаа нь хотын хэмжээнд хүн амын тоогоор гуравдугаарт ордог дүүрэг (хүн амын 16 хувийг эзэлдэг) юм. Уул уурхай, олборлолт болон бусад аж үйлдвэрийн үйл ажиллагааг хэсгүүдийн ердөө зургаан хувь нь үндсэн ажил эрхлэлтийн салбар гэж мэдээлсэн; гэхдээ энэ төрлийн ажил эрхлэлт зарим дүүрэгт илүү төвлөрсөн байгааг тоо баримт харуулж байна. Багануурын хэсгүүдийн 50 хувь, Налайхын хэсгүүдийн 20 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн гол салбарыг аж үйлдвэрийн үйл ажиллагаа нь бүрдүүлдэг хэмээн мэдээлжээ. Нийслэлийн хүн амын 40 хувь нь амьдардаг Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт барилгын салбарт хамгийн олон хүн ажилладаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь)




Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар дүүргээр (хэсгийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл дүүргээр

<b>Нийт</b> 68% Хувийн хэвшил	<b>Багахангай</b> 67% Төрийн байгууллага
<b>Багануур</b> 56% Төрийн байгууллага	<b>Баянгол</b> 74% Хувийн хэвшил
<b>Баянзүрх</b> 63% Хувийн хэвшил	<b>Чингэлтэй</b> 82% Хувийн хэвшил
<b>Хан-Уул</b> 61% Хувийн хэвшил	<b>Налайх</b> 52% Хувийн хэвшил
<b>Сонгинохайрхан</b> 75% Хувийн хэвшил	<b>Сүхбаатар</b> 66% Хувийн хэвшил

Судалгаа хийх хугацаанд Улаанбаатар хотын хэмжээнд 270,079 хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа гэж мэдээлсэн нь насанд хүрсэн хүн амын 30 хувь байна. Багануур дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн ам хамгийн өндөр хувьтай бүртгэгдсэн буюу насанд хүрсэн хүн амын 44 хувь (8061 хүн); харин хөдөлмөр эрхлээгүй хүн ам хамгийн олон бүртгэгдсэн нь Баянзүрх дүүрэгт (70,249 хүн) байгаа нь дүүргийн хэмжээнд насанд хүрсэн хүн амын 33 хувь, нийт ажилгүй иргэдийн 26 хувь байна. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн энэхүү өндөр хувь нь ажил, хөдөлмөр эрхлэлтийн боломжит салбаруудын төрлөөс мөн нэг төрлийн ажлууд байдгаас шалтгаалдаг байж магадгүй гэдгийг анхаарах нь чухал юм. Багануур дүүргийн хэсгүүдийн талаас илүү хэсэг болох 50 гаруй хувь нь уул уурхай, олборлолт болон бусад аж үйлдвэрийн салбарт хамгийн олон хүн ажилладаг гэжээ. Хөдөлмөр эрхлээгүй хүн амын хувиар хоёрт бүртгэгдсэн дүүрэг бол нийслэлийн нийт хүн амын нэг хүрэхгүй хувийг эзэлдэг Багахангай (36%) юм. Хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин 33 хувьтай байна. Баянзүрх бол нийслэлийн хэмжээнд хамгийн олон хүн амтай (нийт хүн амын 24 хувийг эзэлдэг) дүүрэг бөгөөд 2021 онд ирсэн иргэдийн хамгийн өндөр хувьтай (мөн 24%) байгаа дүүрэг тул онцгой ач холбогдолтой юм.

Хөдөлмөр эрхлээгүй хүн ам хамгийн бага бүртгэгдсэн Баянгол дүүрэгт насанд хүрсэн хүн амын 23 хувь нь ажил хөдөлмөр эрхлээгүй, 77 хувь нь ажилтай буюу хөдөлмөр эрхэлж байна. Баянгол дүүрэг нь Улаанбаатар хотын хэмжээнд хүн амын тоогоор гуравдугаарт байдаг бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн хамгийн тэргүүлэх салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа юм. Нийслэлийн хүн амын 14 хувь оршин суудаг Хан-Уул дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин харьцангуй бага буюу 26 хувьтай, 74 хувь нь ажил, хөдөлмөр эрхэлж байна гэж бүртгэгджээ. Хан-Уул дүүрэгт мөн хөдөлмөр эрхлэлтийн тэргүүлэх салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа байна. Улаанбаатар хотын нийт иргэдийн гуравны хоёроос илүү нь хувийн хэвшилд ажилладаг (68 %) гэсэн бол дараа нь төрийн албанд ажилладаг (15 %), хувиараа хөдөлмөр эрхэлдэг (11 %) гэж мэдээлжээ. Багахангай, Багануураас бусад дүүрэгт хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлт давамгайлдаг нь харагдаж байна. Тус хоёр дүүрэгт төрийн байгууллага илүү үүрэгтэй бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн хэв загвар тус тус 67 хувь болон 56 хувийг эзэлж байна. Тэдгээр хоёр дүүрэгт мөн хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин хамгийн өндөр байна гэж мэдээлсэн нь хувийн хэвшилд ажиллах боломж хомс байгаатай холбоотой байх магадлалтай.


## 1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын бууралт болон хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар мэдээлэл нэгтгэгчдийн ажиглалтыг авч үзэх замаар төлбөрийн чадварыг судалсан болно.

Нийтдээ мэдээлэл нэгтгэгчид мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн өмнө (турш) айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай дам яриа сонссон тухайгаа мэдээлжээ. Энэ нь нийтдээ Улаанбаатар хотын хэмжээнд 488,206 хүнд нөлөөлж байна. Хэсгүүдийн 29 хувь нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногт айл өрхүүд хангалттай хоол хүнсгүйдээ санаа зовж байгааг ажигласан гэж мэдээлсэн байв. Энэ нь нийт 405,698 хүнд нөлөөлж байна. Судалгаанаас харахад Сонгинохайрхан дүүрэг үүнд хамгийн их өртсөн дүүрэг бөгөөд хэсгүүдийн 51 хувь нь хүнсний хэрэглээ багассан, 60 хувь нь хоол хүнс хүрэлцэхгүй байна гэсэн санаа зовнилтой байгааг гол мэдээлэл нэгтгэгчид мэдээлжээ.

Хүнсний хүртээмжтэй байдлын асуудал орон сууцны болон холимог хороололтой харьцуулахад гэр хороололд илүү хүнд байна. Хангалттай хоол хүнсгүй гэсэн санаа зовнилд өртсөн хүмүүсийн талаас илүү

Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)




Нийслэлийн дүүргүүдийн 82 хувьд нь талаас бага буюу бараг хэн ч орлого буураагүй гэж мэдээлсэн бол дүүргүүдийн 88 хувьд нь талаас бага буюу бараг хэн ч бүх орлогоо алдсан гэж мэдээлээгүй байна. Дүүргүүдийн 18 хувьд хүн амын 50 ба түүнээс дээш хувь нь орлого буурсан гэж мэдээлсэн нь нийт 265,145 хүнд нөлөөлсөн гэж үзэж байна. Дүүргүүдийн 12 хувьд хүн амын 50 ба түүнээс дээш хувь нь бүх орлогоо алдсан гэж мэдээлсэн бөгөөд нийт 173,794 хүнд нөлөөлжээ. Дахин хэлэхэд Сонгинохайрхан дүүрэгт нөхцөл байдал хамгийн хүнд, орлого буурч, бүх орлогоо алдах (орлогын эх үүсвэр) тохиолдол хамгийн их ажиглагдсан. Цаашилбал, гэр хороололд орлогын бууралт (26%), нийт орлогын алдагдал (19%) байгаа нь дунджаас өндөр байна.

хувь нь (58%) гэр хороололд амьдардаг бол орон сууцны хороололд 25 хувь, холимог хороололд 17 хувь байна. Үүнтэй адилаар хүнсний хэрэглээгээ багассан гэсэн дам ярианд өртсөн иргэдийн 58 хувь нь гэр хороололд амьдардаг иргэд байна.

Хүнсний аюулгүй байдал, дүүргээр (хэсгийн эзлэх хувь)




Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



## 1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн тулгамдсан зүйл бол төлбөрийн чадвар, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлууд юм. Хамгийн чухал тулгамдсан асуудлууд нь орлого хангалтгүй (хэсгүүдийн 47 хувьд мэдээлсэн), хөдөлмөр эрхлээгүй (23%), өр зээлийн дарамт (13%) юм. Орлого хангалтгүй гэсэн асуудал Баянгол дүүрэгт хамгийн их (55%) байгаа бол хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал Багахангай дүүрэгт (83%) нэн өндөр бол өр, зээлийн асуудал Багануур дүүрэгт (18%) хамгийн их тулгарч байна.

Тулгамдаж буй асуудлууд дүүргээр (хэсгийн эзлэх хувь %)






Нийслэлийн хэмжээнд иргэдийн амьжиргааны боломж (25%), автомашины зогсоол (18%), эрүүл мэндийн үйлчилгээ (17%), орон сууц (11%) зэрэг үйлчилгээ авахад хамгийн хүндрэлтэй байна. Багануур (эрүүл мэнд), Баянгол, Баянзүрх (авто машины зогсоол) дүүргээс гадна Улаанбаатар хотын хэмжээнд амьжиргаагаа дээшлүүлэх боломж бололцоог сайжруулах нь хамгийн их анхаарал хандуулах асуудал болж байна. Хөдөлмөрийн насны хүн амын 36 хувь нь ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа Багахангай дүүрэгт (67%) амьжиргаагаа дээшлүүлэх боломж муутай, илүү хүндрэлтэй байгаа нь тогтоогдсон билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг гол бэрхшээл бол гудамж, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжид аюулгүйнэвтрэхдэд бүтэц (орц, гарц) дутмаг (40%), дараа нь тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ (33%), тээврийн үйлчилгээ дутмаг байдал байна.




Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Мэдээлэл нэгтгэгчдээс хэсгийнхээ аюулгүй байдлын нөхцөлийг нэгээс тав хүртэлх оноогоор үнэлэхийг хүссэн бөгөөд нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үг юм. Улаанбаатар хотын хэмжээнд аюулгүй байдлын нөхцөл байдал дундаж (яг 3.0 оноо) гарчээ. Бүх дүүргийн хэмжээнд аюулгүй байдлын нөхцөл харьцангуй бага хэлбэлзэлтэй, бүхэлдэхэд 3 оноотой байв. Мэдээлэл нэгтгэгчдээс мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн өмнө өөрийн хамаарал бүхий хэсэгт нь аюулгүй байдлын зөрчил гарсан эсэх талаар асуусан бөгөөд нийт 20 хувь нь аюулгүй байдлын зөрчил гарсан гэж мэдээлсэн бол 80 хувь нь аюулгүй байдлын зөрчил гараагүй гэж хариулсан. Аюулгүй байдлын зөрчлийн түвшин Сонгинохайрхан дүүрэгт хамгийн их (31%), Багахангай дүүрэгт хамгийн бага (0%) бүртгэгдсэн байна. Тэдгээр гарсан дүн нь нэг талаас хүнсний хүртээмжийн асуудал, төлбөрийн чадварын найдваргүй байдал, нөгөө талаас аюулгүй байдлын зөрчил хоорондоо холбоотойг харуулж байна. Аюулгүй байдлын зөрчил хамгийн их гардаг Сонгинохайрхан дүүрэгт хүнсний хүртээмжтэй байдал алдагдаж байгаа өрхүүд болон орлого нь буурсан эсвэл орлого нь бүрэн алдагдсан иргэдийн тоо хамгийн өндөр байгааг мэдээлсэн. Харин хамгийн цөөн хувь аюулгүй байдлын зөрчил гарсан гэж мэдээлсэн Багахангай дүүрэгт хүнсний хүртээмжгүй байдалтай айл өрх хамгийн цөөн, өдөр тутмын орлого нь буурсан иргэдийн тоо дунджаас доогуур байна.

**Аюулгүй байдал дүүргээр**  
Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдлын зөрчлийн зонхилох хэлбэр нь гудамжны нохой, муурны халдлага (39%) бөгөөд бие махбодын хүчирхийлэл (20%), дээрэм, тонуул (16 хувь) удаалсан байна. Багануур дүүрэгт бие махбодийн хүчирхийлэл хамгийн их (57%) бүртгэгдсэн бол Баянгол дүүрэгт (22%) дээрмийн гэмт хэрэг хамгийн их гарчээ.

Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан талаар мэдээлсэн хэсгүүдийн эзлэх хувь




Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд, дүүргээр (хэсгийн эзлэх хувь)




## 1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

### УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ХООЛ, ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсгүй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС

Хүнсний бус бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бус бүтээгдэхүүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ИНТЕРНЭТ

Интернэтэд холбогдоогүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Интернэтийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### УХААЛАГ УТАС

Ухаалаг утас ашигладаггүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)



Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### 1.8 Ногоон байгууламж

Хэсгийн ахлагч нараас өөрийн хэсгийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарт нэгээс тав хүртэл, нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үнэлгээ өгөхийг хүссэн. Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар Улаанбаатар хотын хэмжээнд 2.5; айл өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар бага зэрэг доогуур буюу 2.4; хувийн хэвшлийн бүтээн байгуулсан цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар 2.3 гэсэн үнэлгээ авсан. Нийтийн эзэмшлийн, айл өрхийн болон хувийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжид хамгийн бага оноог Баянзүрх дүүрэг (2.1, 2.2, 2.3) тус тус авчээ.

Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар


Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



	Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх
Чингэлтэй	3.2	2.9	2.4	2.1
Хан-Уул	2.3	2.4	2.3	2.4
Налайх	2.5	2.4	2.3	2.4
Сонгинохайрхан	2.5	2.4	2.3	2.4
Сүхбаатар	2.5	2.4	2.3	2.4

Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар


Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



	Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх
Чингэлтэй	3.0	2.7	2.4	2.2
Хан-Уул	2.4	2.4	2.5	2.4
Налайх	2.4	2.9	2.5	2.4
Сонгинохайрхан	2.4	2.9	2.5	2.4
Сүхбаатар	2.4	2.9	2.5	2.4

Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн




	Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх
Чингэлтэй	2.7	3.1	2.5	2.3
Хан-Уул	2.4	2.5	2.5	2.5
Налайх	2.6	2.5	2.5	2.5
Сонгинохайрхан	2.6	2.5	2.5	2.5
Сүхбаатар	2.6	2.5	2.5	2.5

### 1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн


Улаанбаатар хотын хэмжээнд замын хөдөлгөөний зонхилох зорчих хэлбэр нь автомашин (хэсгүүдийн 41%-д), автобус, микроавтобус (34%), явган явах (20%) гэж бүртгэгдсэн байна. Хамгийн олон хүн амтай гурван дүүргийн хоёрт (Баянзүрх, Баянгол) үндсэн тээврийн хэрэгсэл нь автомашин 48 хувь ба 50 хувь байна. Харин Сонгинохайрхан (хүн амаараа хоёрдугаарт ордог) дүүргийн тээврийн үндсэн хэлбэр нь автобус эсвэл микроавтобус (42%) байна. Багахангай аймагт ихэвчлэн явган алхдаг гэж мэдээлсэн бөгөөд энэ нь хэсгүүдийн 67 хувийг эзэлж байна.

Хэсгүүдийн 37 хувьд хэсгийн ахлагч нар айл өрхүүдийн тал буюу түүнээс дээш хувь нь хувийн тээврийн хэрэгсэл эзэмшдэггүй хэмээн мэдээлсэн. Энэ үзүүлэлт Налайх дүүрэгт (түгээмэл тээврийн хэлбэр нь такси байсан) хамгийн өндөр байсан бөгөөд тус дүүргийн иргэдийн 52 хувь нь хүн амын тал буюу түүнээс дээш хувь нь хувийн тээврийн хэрэгсэл эзэмшдэггүй гэж, хэсгүүдийн 2 хувь нь хувийн машинтай хүн бараг байхгүй гэж мэдээлсэн байна.

Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

Нийт	Багахангай
41% Авто машин	67% Алхах
Багануур	Баянгол
50% Авто машин	50% Авто машин
Баянзүрх	Чингэлтэй
48% Авто машин	52% Автобус, микро автобус
Хан-Уул	Налайх
43% Авто машин	32% Такси
Сонгинохайрхан	Сүхбаатар
42% Автобус, микро автобус	50% Авто машин

Улаанбаатар хотын хэмжээнд замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн бэрхшээл нь авто машины зогсоолын хүрэлцээ муу (хэсгүүдийн 23%), замын ачаалал их 17 хувь, хүүхдэд зориулсан нийтийн эзэмшлийн талбай байхгүй (17%), замын эвдрэл (11%), тээврийн хэрэгслүүд хэт хурдан явдаг (8%) гэсэн асуудлууд байна. Авто машины зогсоол хүрэлцэхгүй байгаа Баянгол (33%), Сүхбаатар (31%), Налайх (30%) дүүрэгт хамгийн их бүртгэгдсэн асуудал нь Баянгол, Баянзүрх, Хан-Уул (нийт 22%) дүүрэгт замын хөдөлгөөний ачаалал хамгийн их байна.


Замын хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй 5 асуудал, дүүргээр (хэсгийн эзлэх хувь)

	Машины зогсоол байхгүй	Ачаалал ихтэй зам	Хүүхдийн тоглох нийтийн талбай хомс/байхгүй	Зам эвдрэлтэй	Машины хэт хурдан явж байна
Нийт	23%	17%	17%	11%	8%
Багахангай	0%	0%	17%	50%	0%
Багануур	29%	0%	29%	18%	6%
Баянгол	33%	22%	17%	4%	4%
Баянзүрх	20%	22%	13%	13%	7%
Чингэлтэй	23%	12%	19%	15%	8%
Хан-Уул	16%	22%	15%	9%	12%
Налайх	30%	2%	24%	24%	10%
Сонгинохайрхан	16%	15%	19%	13%	11%
Сүхбаатар	31%	13%	14%	6%	9%


### 1.10 Хүүхэд ба боловсрол

Улаанбаатар хотын хэмжээнд 0-5 насны хүүхдүүдийн 30 хувь нь цэцэрлэгт хамрагдаагүй гэж мэдээлсэн байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд 6-17 насны хүүхдүүдийн 3 хувь нь сургуульд хамрагдаагүй байна гэж мэдээлжээ. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн тоо Налайх дүүрэг (36%), Баянгол дүүрэг (35%), Баянзүрх дүүрэг (33%) байна. 6-17 насны хүүхдүүдийн тоо хамгийн их бүртгэгдсэн Баянзүрх дүүрэгт (77,346) мөн сургуульд хамрагдаагүй хүүхдийн тоо хамгийн өндөр буюу 4 хувь байна. Түүнчлэн боловсролын салбарт тулгамдаж буй ямар асуудал байгааг мэдээлэл нэгтгэгчдээс юм. Хэсгүүдийн 39 хувь нь боловсролтой холбоотой тулгамдсан асуудал байхгүй гэж хариулсан бол боловсролын хоёр дахь тулгамдсан асуудал нь сургуулийн зай хэт хол (26%), сургууль, анги танхимын хүрэлцээ муу (20%) тул хэт ачаалал үүсгэдэг гэж хариулсан байна. Сүхбаатар болон Хан-Уул дүүрэгт сургууль хүртэлх зай хол байгаа нь хамгийн хүндрэлтэй байгаа (32%) бол сургууль, анги танхимын хүрэлцээний асуудал хамгийн тааруу Баянзүрх дүүрэгт (27%) сургуульд суралцах ирц хамгийн бага байна. Улаанбаатар хотын хэмжээнд хэсгийн дөнгөж зургаахан хувьд чанар муутай боловсролыг асуудал гэж мэдээлсэн бол Баганхангай дүүрэгт илүү тулгамдсан асуудал болох нь тогтоогдож, хэсгүүдийн 50 хувьд нь энэ асуудлыг мэдээлжээ.

Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)



Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Хүүхдийн нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал тэдний хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Улаанбаатар хотын хэмжээнд хүүхдүүдэд хамгийн тулгамдсан асуудал бол хүүхдийн клуб, спортын төвүүд дутмаг (хэсгүүдийн 40 хувьд мэдээлсэн), сургуулиудын зай хол (18%), гэрээс хичээллэхэд интернэтэд холбогдох боломж болон бусад хэрэгсэл хангалтгүй байдал (10%) гэж мэдээлсэн юм. Хүүхдийн тоо өндөр хувийг эзэлдэг Налайх дүүргийн хүүхдийн боловсролд тулгарч байгаа хамгийн тулгамдсан асуудал бол хүүхдийн клуб, спортын төв дутагдалтай байгаа явдал юм.

Хүүхдэд тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

	Хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх секц, дугуйлан байхгүй	Сургуулиуд хэтэрхий хол зайтай байна	Гэрээр хичээллэхэд зориулсан интернэт/хэрэгсэл ашиглах боломжгүй	Сургуулийн сургалтын чанар муу	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал
Нийт	40%	18%	10%	9%	6%
Багахангай	67%	0%	0%	33%	0%
Багануур	29%	18%	9%	3%	29%
Баянгол	34%	18%	4%	11%	9%
Баянзүрх	40%	20%	11%	7%	5%
Чингэлтэй	43%	11%	16%	10%	3%
Хан-Уул	34%	18%	9%	14%	7%
Налайх	36%	32%	4%	6%	0%
Сонгинохайрхан	45%	18%	14%	8%	3%
Сүхбаатар	44%	22%	6%	7%	6%

# Дүгнэлт болон ЗӨВЛӨМЖ

## Дүгнэлт

Энэхүү тайлангийн үр дүнд нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал, ялангуяа ажил хөдөлмөр эрхлээгүй, орлого муутай, ажил олж чадахгүй байгаа хүмүүстэй холбоотой асуудлуудыг онцолж байна. Нийслэл хотын хэмжээнд иргэдийн авахад хамгийн хүндрэлтэй байдаг үйлчилгээ бол амьжиргааны боломжоо дээшлүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, хамгийн тулгамдсан гурван асуудал нь орлого хангалтгүй (47%), хөдөлмөр эрхлээгүй хүн ам (23%), өр, зээл (13%) юм. Цаашилбал, хөдөлмөрийн насны хүн амын 30 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Эдгээр хүчин зүйлс нь айл өрхийн хүнсний хүртээмжтэй байдлыг баталгаажуулах чадамжид ихээхэн нөлөөлж болзошгүй юм.

Сонгинохайрхан дүүрэгт орлого буурсан, мөн бүх орлогоо алдсан иргэдийн тоо хамгийн өндөр гарсан байна. Энэ нь хүнсний хүртээмжтэй байдалд ихээхэн сөргөөр нөлөөлөх магадлалтай байгаа нь тоон мэдээллээр батлагдсан дүгнэлт юм. Хэсгүүдийн 60 хувь нь оршин суугчид хүнсний хэрэглээгээ бууруулсан гэсэн дам яриа байгааг, 51 хувь нь хоол хүнс хүрэлцэхгүй байх вий гэж санаа зовниж байгааг мэдээлжээ.

Хүнсний болон орлогын тогтворгүй байдлын аль аль нь орон сууцны болон холимог хорооллоос (гэр хороолол, байшин хороолол) илүү гэр хороололд өндөр байгаа нь эдгээр газарт гэмт хэргийн гаралт ихсэх, эрүүл мэнд муудах, нийгмийн эв нэгдэл буурах зэрэг сөрөг үр дагавартай байх магадлалтай.

Нийтдээ 6-17 насны хүүхдүүдийн 3 хувь нь сургуульд явдаггүй гэсэн мэдээлэл байна. Боловсролтой холбоотой хамгийн чухал асуудал бол сургууль хүртэлх зай хол (26%) бөгөөд энэ нь замын түгжрэлд ноцтой нөлөөлдөг байж болзошгүй байна. 0-5 насны хүүхдүүдийн 30 гаруй хувь нь цэцэрлэгт хамрагдахгүй байгаагаас харахад эцэг эхчүүд, ялангуяа эхчүүд хүүхдээ харж, ажил эрхлэх боломжгүй болж байна гэсэн үг юм.

## Зөвлөмж

- Орон нутгийн, ялангуяа хувийн хэвшлийн эдийн засгийг идэвхжүүлэх замаар ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа иргэдийг дэмжих. Ялангуяа аж үйлдвэрийн салбараас гадуур орших жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүүгийн хөшүүргээр хангах замаар дэмжихийг зөвлөж байна.
- Эмзэг бүлгийн өрхүүдэд ялангуяа орлого, хүнсний хүртээмжтэй байдал хамгийн хүнд байгаа гэр хороолол болон бусад газарт хүнсний багц тараах зэргээр богино хугацааны зорилтот дэмжлэг үзүүлэх;
- Эцэг эхчүүдийн цалин хөлсгүй ажлын ачааллыг хөнгөвчлөх, ажлын байрыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор шинээр цэцэрлэг, сургуулиас гадуурх хүүхдийн төвүүдийг барих;
- Сонгинохайрхан дүүрэгт иргэд их хэмжээгээр орлогоо алдаж байгаа шалтгааныг цаашид судалж, дүн шинжилгээ хийх;
- Сургуулийн зай хол болон замын түгжрэл хоёрын хооронд ямар холбоо байж болох талаар илүү нарийвчилсан судалгаа хийх;
- Хот доторх болон хот хоорондын хөдөлгөөнийг салгаж, шилжин ирэгсдийн уугуул байршил, шилжин явагсдын шилжиж очсон газар зэргийг олохын тулд ДТМ мэдээлэл цуглуулах хэрэгслийг улам боловсронгуй болгон гүнзгийрүүлэн судлах;
- "Гэр бүлийн шалтгаан"-ыг нарийвчлан тодруулж, ирэх, явах болсон шалтгаануудын дэлгэрэнгүй жагсаалтыг гаргах замаар шилжих хөдөлгөөний үндсэн шалтгааныг илүү сайн ойлгохын тулд ДТМ хэрэгслийг улам боловсронгуй болгох;



© У.Одбаяр

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.